

МӨНГӨ УГААХ ГЭМТ ХЭРЭГ, ТҮҮНТЭЙ ТЭМЦЭХ АРГА БАРИЛ, ДЭЛХИЙН ЧИГ ХАНДЛАГА

Б.Айбек /Ph.D/

Судалгаа, мэдээлэл, сургалтын төвийн захирал

Мөнгө гэдэг зүйл төлбөрийн хэрэгсэл болсон үеэс магадгүй мөнгө угаах гэдэг ойлголт бий болсон байж болох талтай гэж барууны эрдэмтэн судлаачид үздэг. Учир нь түүхийн аль ч цаг үед мөнгө үүссэн цагаасаа эхлэн хаад ноёдод, эрх мэдэлтнүүдэд хуулийг гуйвуулах, өөрсдийн эрх мэдэл, байр суурийг бэхжүүлэх чухал хэрэгсэл болж баян тансаг амьдрахын зэрэгцээ хуулийг ч өөрийн эрх ашигт нийцүүлэн гаргахад чухал үүрэг гүйцэтгэж ирсэн байна. **Мөнгө угаах гэдэг нь гэмт хэрэг үйлдэж олсон эд зүйлс, ашиг, орлогын эх үүсвэрийг нуун далдалж уг мөнгө болон эд зүйлсийг хууль ёсны мэтээр халхавчлан эдийн засгийн эргэлтэд оруулах, хэлбэр дүрсийг хувиргах бүхий л үйлдлийг ойлгодог.** Богино хугацаанд их хэмжээний ашиг олох нь уг гэмт хэргийн зорилго байдаггүй бөгөөд гол нь гэмт хэрэг үйлдэж олсон гэх ул мөр үлдээхгүй байх нь чухал байдаг.

Мөнгө угаах гэмт хэрэгтэй тэмцэх зорилго бол ахуйн хүрээнд эсхүл хохирол багатай эдийн засгийн гэмт хэргийн халдлагад өртсөн эд зүйлийг хамгаалахад чиглэдэггүй бөгөөд албан тушаал, авлигын бүх төрлийн гэмт хэрэг, татвар төлөхөөс зайлсхийх, хүний наймаа, хууль бус зэвсгийн худалдаа, мансууруулах төрлийн гэмт хэрэг, үндэстэн дамнасан гэмт хэргүүд, терроризм, байгалийн баялагтай холбоотой гэмт хэргээс олсон хууль бус орлого, эдийн болон эдийн бус давуу талыг илрүүлэх, олон улс болон тухайн улсын эдийн засгийн цэвэр урсгалыг хар зах зээлээс хамгаалж бохир мөнгөний урсгал нөгөө талаар хууль бус санхүүжилтийг таслан зогсооход чиглэгддэг.

Мөнгө угаах гэмт хэрэг үндсэн 3 үе шаттай явагддаг.

1.Placement /Einspeisung/ буюу байршуулах үе: Эхний үе шатанд хууль бусаар олсон мөнгө, эд зүйлийг хаа нэгтээ байршуулдаг. Тухайлбал: Өөр хүний нэр дээрх хадгаламж болон харилцах данс нээлгэх, үнэт цаас, чек худалдан авах, алт үнэт зүйлсийг хадгалуулах г.м

2.Layering /Verschleierung/ буюу нуун далдлах үе Энэ үе шатанд тухайн мөнгө, эд зүйлсийн гарал үүслийг нь нуун далдлах зорилгоор байршуулсан зүйлээрээ хөрөнгө оруулалт, хандив тусламж, хүүтэй зээл, бусдын нэр дээр объект, хөдлөх болон үл хөдлөх эд хөрөнгө худалдан авах, асрамжийн болон буяны байгууллага, сан, компани, банк байгуулах, тэдгээрийг даатгуулах зэрэг үйлдэл хийгддэг.

3.Integration /Integration/ буюу эргэлтэд оруулах үе: Сүүлийн энэ үе шатанд гарал үүслийг нь нуусан мөнгийг хууль ёсны эдийн засгийн эргэлтэд оруулдаг. Өөрөөр хэлбэл хөрөнгө оруулалт хийсэн газраа зарах, түрээслэх замаар ашиг олох, зээлсэн мөнгөнийхөө хүүг авах, компани, сангийн тодорхой хувь эзэмшигч болох, үүсгэн байгуулсан банкныг санаатай дампууруулж даатгалын байгууллагаас их хэмжээний нөхөн төлбөр авах гэх мэт.¹

¹ Эх сурвалж: Монгол банк, Санхүү мэдээллийн албаны мэдээлэл.

Мөнгө угаах гэмт хэрэг үүсэж хөгжсөн түүхийн цаг үе, байдлаас харахад эдийн засгийн хувьд тогтворгүй, ядуу буурай эсхүл жижиг эдийн засагтай гадаад улс орнуудын зээл, буцалтгүй тусламж хөрөнгө оруулалтад тулгуурлан хөгжиж буй орон мөн гадаадын хөрөнгө оруулагчдын мөнгөний эх үүсвэрийг шалгах боломж муутай улсад үйлдэгдэх нь түгээмэл байдаг.

Олон улсын санхүүгийн гэмт хэрэгтэй тэмцэх байгууллага буюу ФАТФ-аас батлан гаргасан мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх олон улсын стандарт /ФАТФ-ын 40 зөвлөмж/-ын дагуу гишүүн улс орнууд мөнгө угаах гэмт хэрэгт тооцох суурь гэмт хэргүүдийг тодорхойлон, мөнгө угаахтай тэмцэх, урьдчилан сэргийлэх арга хэмжээнүүдийг авч ажиллаж байна.

Дэлхий ертөнц даяаршиж, бүхий л зүйл цахим дижитал болж буй энэ үед олон улсын мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх үйл ажиллагаа санхүүгийн үйл явц, технологийн хөгжил буюу олон улсын мөнгөний шилжүүлэг, харилцааны арга хэрэгслийн хөгжилтэй хамт хөгжиж байна. Ийнхүү мөнгө угаах үйл ажиллагаа нь санхүүгийн байгууллагуудаар дамжиж байгаа тул энэ төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, тэмцэх хамгийн чухал үүргийг санхүүгийн байгууллагууд гүйцэтгэх юм. Тиймээс улс орнууд мөнгө угаахтай тэмцэх тухай холбогдох хуулиудаараа санхүүгийн байгууллагын тодорхойлолт болон мэдээлэх үүрэг бүхий санхүүгийн байгууллагын нэр төрлийг улам өргөжүүлж, тэдгээрт тавих шаардлага, хяналт, хариуцлагыг чангаруулсаар байна.

Мөнгө угаах гэмт хэрэгтэй тэмцэхэд эрсдэлд суурилсан аргыг хамгийн өргөн хэрэглэж байна. Компани бүрийн эрсдэлийн түвшин өөр өөр байдаг учраас үүнийг эрсдэлд тулгуурлан удирддаг. Нэгдүгээрт, эрсдэлийн үнэлгээ хийж, хоёрдугаарт, эрсдэлийн түвшинд тохирсон хяналтын үйл явц хэрэгжүүлдэг. Эрсдэлд суурилсан хандлагын гол зорилго нь компанийн мөнгө угаахтай тэмцэх үүргийн нэг болох хэрэглэгчийн дансыг нээхээс өмнө эрсдэлийн үнэлгээ хийж, үйлчлүүлэгчийн эрсдэлийн түвшнийг тодорхойлох явдал юм.

Мөн улс орнууд санхүүгийн үйл явц болон мөнгө угаах үйл ажиллагааны хөгжилтэй холбогдуулан санхүүгийн зохицуулагч, хууль сахиулах байгууллага болон санхүүгийн байгууллагууд санхүүгийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, илрүүлэх, тэмцэх, хяналтын тогтолцоог сайжруулах хүрээнд санхүүгийн технологи буюу финтек, түүний төрлүүд болох регтек, саптек шийдлүүдэд / робот үйл явцын автоматжуулалт, хиймэл оюун ухаан, машин сургалт/ суурилсан шинэ техник технологийг ашиглан, өөрсдийн системийг сайжруулан, үйл ажиллагаандаа нэвтрүүлж эхлээд байгаа бөгөөд олон улсад мөнгө угаах гэмт хэрэгтэй тэмцэхэд чиглэсэн дараах шийдлүүдийг ашиглаж байна:

1) **Харилцагч таньж мэдэх**

Харилцагчийн таньж мэдэх ажиллагааг хуульд заасан шаардлагын дагуу богино хугацаанд, үнэн зөв бодит мэдээллийг нэгдсэн сүлжээнээс түргэн хугацаанд гаргаж авах шийдэл.

2) **Өгөгдөлд дүн шинжилгээ хийх, тайлан мэдээ боловсруулах**

Зохицуулагч байгууллагаас мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн дагуу олон төрлийн хяналтыг хийхээр заасан байдаг. Тэгвэл РегТек ашиглан эдгээр гүйлгээнд хяналт тавьж, тайлан мэдээг богино хугацаанд зохицуулагч байгууллагад хүргүүлэх шийдэл.

3) Мэдээллийн аюулгүй байдлыг хангах

Өнөөдөр мянга мянган хакерууд өдөр тутамд санхүүгийн байгууллагын сүлжээнд халддаг. Тэгвэл эдгээр олон мянган халдлагаас регтек шийдлээр хамгаалж болдог байна.

4) Гүйлгээний хяналт

Банк санхүүгийн байгууллага өдөрт сая сая санхүүгийн гүйлгээ дамжуулдаг. Эдгээр гүйлгээнд 24 цагийн турш хяналт тавих ямар ч боломжгүй эсвэл маш их хүн хүч зардал шаардсан ажил болно. Үүнийг РегТек шийдлээр өдрийн 24 цаг хянаж болно.

I. АМЕРИКИЙН НЭГДСЭН УЛС

1970 онд АНУ-ын конгресс мөнгө угаах үйл ажиллагааг хэцүү болгож, АНУ-ын банкнууд мөнгө угаах хууль бус үйлдлийг ухамсарлахгүй байхаас урьдчилан сэргийлэх, гэмт хэргийн мөрдөн шалгах, татвар болон бусад хориг арга хэмжээ авахтай холбогдуулан шаардлагатай мэдээллийг холбогдох санхүүгийн байгууллагаас авах зорилгоор Банкны нууцын тухай хууль (Bank Secrecy Act of 1970 BSA)-ийг баталснаас хойш мөнгө угаах үйл ажиллагаатай тэмцэх хүрээнд гэмт хэргийн хяналтын тухай хууль, мөнгө угаах үйл ажиллагааг хянах тухай хууль, мансууруулах бодистой тэмцэх тухай хууль, Аннунзио-Вайлийн мөнгө угаахтай тэмцэх тухай хууль, мөнгө угаах үйлдлийн таслан зогсоох тухай хууль, Мөнгө угаах болон санхүүгийн стратегийн тухай хууль, АНУ-ын эх оронч үйл ажиллагааны тухай хууль, мөнгө угаахтай тэмцэх тухай хуулиудыг тус тус батлан гаргасан бөгөөд хууль бүрийн зохицуулалт нь дор дурдсантай адил байна:

1) Банкны нууцын тухай хууль (Bank Secrecy Act of 1970 BSA)

Банкны нууцын тухай хуулиар мэдээлэх үүрэг бүхий субъектэд дотоодын арилжааны болон хөрөнгө оруулалтын банк, брокер-дилер, бараа бүтээгдэхүүний брокер, казино, мөнгө дамжуулагч, төлбөр тооцооны процесс, хамтын санг оруулсан. Хуулийн дагуу мэдээлэх үүрэг бүхий санхүүгийн байгууллагууд нь АНУ-ын Засгийн газарт мөнгө угаах үйл ажиллагааг илрүүлэх, урьдчилан сэргийлэхэд нэгдүгээрт, нэг харилцагчаас өдөр тутмын нийт бэлэн мөнгөний гүйлгээ 10,000 ам.доллороос дээш бол мэдээлэх, хоёрдугаарт, мөнгө угаахтай холбоотой сэжигтэй гүйлгээг мэдээлэх гэсэн 2 арга замаар тусалдаг байна. Ингэхийн тулд санхүүгийн байгууллагууд нь харилцагчийг зөв тодорхойлохын зэрэгцээ харилцагчийн санхүүгийн гүйлгээний тодорхой цаасан мэдээллээр хангах чадвартай байх ёстой. Өөрөөр хэлбэл, санхүүгийн байгууллага нь өөрөө мөнгө угаахтай тэмцэх хөтөлбөрийг

хэрэгжүүлэх тогтолцоотой байхыг шаардсан бөгөөд хамгийн багадаа дотоод хяналтын журам, бодлоготой байх, зөвлөмж хариуцсан ажилтныг томилох, ажилтнуудыг тасралтгүй сургах, хөтөлбөрийг турших аудиторын хараат бус байдлыг хангасан байхыг шаардсан байна².

2) *Гэмт хэргийн хяналтын тухай хууль (The Comprehensive Crime Control Act of 1984)*

Гэмт хэргийн хяналтын тухай хуулийг хар тамхины наймаатай тэмцэх арга замыг баяжуулах зорилгоор баталсан. Уг хуулиар мөнгө угаахыг гэмт хэрэгт оруулан тооцож, хууль бусаар олсон орлогыг хураан авахаас гадна зөрчил бүрд иргэний болон эрүүгийн хариуцлага хүлээлгэх талаар зохицуулсан. Тодруулбал, 1000 ам.доллороос их хэмжээний хүнд гэмт хэрэгт 15,000 хүртэл ам.доллороор торгох, эсхүл 5 жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэхээр заасан байна.

Хуулийн дараах 2 заалт Засгийн газарт мөнгө угаах гэмт хэргийг илрүүлэх боломжийг эрс нэмэгдүүлж өгсөн гэж үздэг. *нэгдүгээрт*, хилийн төлөөлөгч /алба хаагчдад мэдэгдээгүй авч яваа их хэмжээний валютыг тээвэрлэж байгааг хайж илрүүлэх боломж олгосон. *хоёрдугаарт*, мэдээлэл өгснийх төлөө мэдүүлэг гаргагчдад шагнал, урамшуулал олгох эрхийг өгсөн³.

3) *Мөнгө угаах үйл ажиллагааг хянах тухай хууль (The Money Laundering Control Act of 1986)*

Мөнгө угаах үйл ажиллагааг хянах тухай хуулиар мөнгө угаах үйл ажиллагааг холбооны гэмт хэрэг гэж тооцож, холбооны прокурорын газар нь холбооны шүүхээр мөнгө угаах үйлдлийг шийдвэрлүүлэх боломжтой болсон. Мөн үйл ажиллагааг техникийн хувьд хуулийн параметруудад оруулахгүйн тулд зохион байгуулахыг хууль бус гэж үзсэн. Мөн мөнгө угаах үйл ажиллагааг илрүүлж, урьдчилан сэргийлэхгүй байх тохиолдолд эрүү болон иргэний хариуцлага ногдуулахаар зохицуулсан. Үүнд: 500,000 хүртэл ам.доллороор торгох эсхүл 20 жил хүртэл хугацаагаар хорих, эсхүл хоёуулангийн нь ногдуулахаар заасан байна. Санхүүгийн байгууллага нь хуулийн заалтыг дагаж мөрдөхийн тулд журмыг хэрэгжүүлэх шаардлагатай болсон.

4) *Мансууруулах бодистой тэмцэх тухай хууль (The Anti-Drug Abuse Act of 1988)*

Хуулиар санхүүгийн байгууллагын тодорхойлолтыг илүү өргөжүүлэн, мэдээлэх үүрэг бүхий этгээдийн мэдээлэх үйл ажиллагааны хэмжээг багасгасан. Машины худалдаачид болон үл хөдлөх хөрөнгийн хаалтын агентуудыг мэдээлэх үүрэг бүхий санхүүгийн байгууллагад оруулсан. Түүнээс

² <https://www.fincen.gov> United States Department of the Treasury Financial Crimes Enforcement Network | FinCEN.gov

³ Michael J. Anderson, MBA Tracey A. Anderson, JD, LL.M., CPA "Anti-Money Laundering: History and Current developments" (PDF) Anti-Money Laundering: History and Current Developments (researchgate.net)

гадна мэдээлэх шаардлагатай гүйлгээний хэмжээг 3,000.50 ам.доллар болгон бууруулж, гэмт хэрэгтэн нь уг хуулийг зөрчиж байх үед хэн нэгэн хүн нас барсан бол хар тамхины гэмт хэрэг болон цаазаар авах ялын доод хэмжээг ногдуулахаар заажээ.

5) *Аннунзио-Вайлийн мөнгө угаахтай тэмцэх тухай хууль (The Annunzio-Wylie Anti-Money Laundering Act of 1992)*

Аннунзио-Вайлийн мөнгө угаахтай тэмцэх тухай хууль нь мөнгө угаах үйл ажиллагааны эсрэг арга хэмжээ авах Засгийн газрын эрх мэдлийг бэхжүүлсэн бөгөөд банкны нууцын тухай хуулийн зөвлөх групп (Bank Secrecy Act Advisory Group - BSAAG)-ыг байгуулсан. BSAAG нь мөнгө угаахын эсрэг хөтөлбөрийг бэхжүүлэх, мөнгөн тэмдэгтийн тайлангийн маягтыг хялбаршуулах талаар сангийн яаманд зөвлөгөө өгөх зорилгоор байгуулагдсан 30 гишүүний бүрэлдэхүүнтэй тусгай комисс юм. Уг хуулиар мөнгө угаах гэмт хэрэг үйлдэх хуйвалдаан нь тухайн гэмт хэрэгтэй адил шийтгэлтэй байх, онлайн шилжүүлгийн баталгаажуулалт, тэмдэглэл/бүртгэл/-ийг хөтлөхийг шаардсан, банк санхүүгийн зөрчилд илүү хүнд шийтгэлийг ногдуулсан, бэлэн мөнгө, мөнгөн хэрэгслийг хураан авахтай холбоотой иргэний хэргийн зарим нэг хамгаалалтыг хасахаар өргөжүүлсэн, санхүүгийн байгууллагууд сэжигтэй үйл ажиллагааны тайлан гаргаж, мэдээлэх асуудлуудыг зохицуулсан байна.

6) *Мөнгө угаах үйлдлийг таслан зогсоох тухай хууль (Money Laundering Suppression act of 1994)*

Энэхүү хуулиар санхүүгийн үйлчилгээ үзүүлдэг байгууллагуудад мэдээлэх үүргийг давхар өгч, санхүүгийн байгууллагын тодорхойлолтыг өргөжүүлэн, банкнуудад нэмэлт үүрэг хүлээлгэсэн. Санхүүгийн үйлчилгээний байгууллагуудад хяналтын ажилтныг бүртгүүлэхийг үүрэг болгосон бөгөөд үүнийг зөрчсөн тохиолдолд гэмт хэрэгт тооцохоор заасан байна. Санхүүгийн байгууллагуудыг дотоод сургалт, хөтөлбөрийг сайжруулахыг шаардаж санхүүгийн байгууллагуудын үүрэг хариуцлагыг өргөжүүлсэн. Харин сэжигтэй гүйлгээний тайлангийн зарим шаардлагыг хялбаршуулсан байна.

7) *Мөнгө угаах болон санхүүгийн стратегийн тухай хууль (Money laundering and Financial Strategy Act of 1998)*

Энэ хуулиар мөнгө угаах үйл ажиллагаатай тэмцэхэд холбооны, муж, орон нутгийн төвлөрсөн бус хүчин чармайлт гол асуудал гэж тодорхойлж, сангийн яам болон бусад агентлагууд мөнгө угаахын эсрэг үндэсний стратегийг боловсруулахыг үүрэг болгосон. Мөн мөнгө угаах үйл ажиллагаа гол явагддаг бүсэд холбооны, муж, орон нутгийн байгууллагуудын хүчин чармайлтыг төвлөрүүлэхийн тулд өндөр зэрэглэлийн мөнгө угаахтай холбоотой санхүүгийн гэмт хэргийн бүс нутгийн ажлын хэсэг / High Intensity Money Laundering and Related Financial Crime Area ("HIFCA") Task Force /

байгуулсан. Санхүүгийн байгууллагуудад хяналт шалгалтын ажилтнуудыг мөнгө угаах үйл ажиллагааг илрүүлэх талаар сургахыг үүрэг болгосон байна.

- 8) *Терроризмыг таслан зогсооход шаардлагатай зохих арга хэрэгслээр хангаж, Америкийг нэгтгэх, бэхжүүлэх тухай хууль /АНУ-ын эх оронч үйл ажиллагааны тухай (Uniting and Strengthening America by Providing Appropriate Tools Required to Intercept and Obstruct Terrorism Act of 2001 ("USA Patriot Act"))*

АНУ-ын эрх оронч үйл ажиллагааны тухай хуулиар дотоодын харилцагчийн нэр, хаяг, татвар тодорхойлох дугаар зэрэг үндсэн мэдээллийг цуглуулах харилцагчийг тодорхойлох СІР, харилцагч хэн болохыг тодорхойлох КҮС-ийг гадаад харилцагчид мөн хэрэгжүүлж гадаад харилцагч нарын мэдээллийг цуглуулах зохицуулалтыг хийсэн. Энд гадаадын харилцагчийн хувийн банкны дансны талаарх мэдээллийг нэмэлтээр шалгахыг хамруулсан. Дотоодын банк гадаадын халхавч банктай харилцагчийн данстай байхыг хориглосон. Террорист үйл ажиллагааг санхүүжүүлэх нь уг хуулийн дагуу гэмт хэрэг байхаар заасан. Мөн уг хуулиар Засгийн газарт нэхэмжлэл гаргаж, гадаадын банкны дансыг хураан авах эрхийг олгосон. Санхүүгийн байгууллагын тодорхойлолтыг өргөжүүлж, үнэт цаасны брокер, газар доорх банкнуудыг нэмж, мэдээлэх үүрэг бүхий байгууллагын хамгаалалтыг сайжруулсан байна.

- 9) *Мөнгө угаахтай тэмцэх тухай хууль (The Anti-Money Laundering Act of 2020 - AML)*

Мөнгө угаахтай тэмцэх тухай хууль нь 5 бүлэг, 56 зүйлээс бүрдсэн 86 хуудас бүхий хууль бөгөөд хуулийн зорилго нь дараах байдлаар тодорхойлогдсон байна:

1. АНУ-ын тодорхой хувьцаат болон хязгаарлагдмал хариуцлагатай компаниуд тайлан тавих шаардлагыг багтаасан эцсийн эзэмшигчийн мэдээллийн тайлангийн системийг бий болгох,
2. AML/CFT зааварчилгааны эрсдэлд суурилсан аргачлалыг дугаарлах,
3. AML/CFT системийг шинэчлэх,
4. АНУ-ын Сангийн яамны санхүүгийн гэмт хэрэг мөрдөх сүлжээ буюу FinCEN-ийн үүрэг-эрх мэдэл-чиг үүргийг өргөжүүлэн, АНУ-ын банканд харилцагчийн дансыг хадгалж байгаа гадаад банкнуудыг шүүх-мөрдөн шалгах эрх мэдлийг олгосон.
5. Санхүүгийн байгууллага, АНУ-ын санхүүгийн зохицуулагч байгууллага, гадаадын санхүүгийн зохицуулагч байгууллага хоорондын хамтын ажиллагаа, харилцан мэдээлэл солилцохыг чухалчилж, хяналт шалгалтыг нэн тэргүүнд тавихыг уялдуулах.

Мөнгө угаахтай тэмцэх тухай хууль, түүнийг төлөөлөх Банкны нууцын тухай хуульд шинэчлэл хийж, төрийн болон хувийн хэвшлийн салбарын урь хугацааны асуудлуудыг шийдвэрлэхийн тулд АНУ-ын хууль тогтоогч,

зохицуулагч, санхүүгийн салбарын олон жилийн хүчин чармайлтын үр дүн юм. Мөнгө угаахтай тэмцэх тухай хуулиар тогтоосон дээрх цогц өөрчлөлтүүд нь АНУ-ын одоогийн төвлөрсөн хуулийн хүрээнд биш, харин санхүүгийн гэмт хэрэгтэй тэмцэх дэлхий нийтийн дэглэмд ойртуулах болно гэж үзжээ.

1. Эцсийн өмчлөгчийн мэдээллийг тайлагнах шинэ шаардлага:

Мөнгө угаахтай тэмцэх тухай хууль нь АНУ-д үйл ажиллагаа явуулахын тулд бүртгүүлсэн гадаад улсын хуулийн дагуу байгуулагдсан АНУ-ын хувьцаат, хязгаарлагдмал хариуцлагатай компаниуд болон бусад ижил төстэй байгууллагын шинэ эцсийн өмчлөгч/эзэмшигчийг бүртгүүлэхийг шаардсан бөгөөд бүртгүүлэх компани нь компанийг үүсгэн байгуулах, бүртгүүлэх явцын нэг хэсэг болгон эцсийн эзэмшигч тус бүрийн тодорхой таних мэдээллийг агуулсан тайланг санхүүгийн гэмт хэрэгтэй тэмцэх сүлжээнд хүргүүлэх үүрэгтэй.

Дараах компаниуд эцсийн өмчлөгчийн мэдээллийг тайлагнахаас чөлөөлсөн байна:

- Эцсийн эзэмшигчийн мэдээллийг нийтэд болон холбооны зохицуулагчдад аль хэдийн ил болгох үүрэг хүлээсэн компани /олон нийтэд худалдаалагдсан компани, банк, даатгалын компани, бүртгэлтэй санхүүгийн үйлчилгээний байгууллага, зуучлал, хөрөнгө оруулалтын компани, хөрөнгө оруулалтын зөвлөх/
- Худалдааны гадаад валютын арилжаа эрхлэгчид,
- Бүртгэлтэй олон нийтийн санхүү төлбөр тооцооны фирмүүд,
- Хөрөнгө оруулалтын зөвлөх, АНУ-ын зуучлалын байгууллага болон банкны үйл ажиллагаа явуулдаг болон зөвлөгөө өгдөг нийтийн хөрөнгө оруулалтын байгууллага

Санхүүгийн гэмт хэрэгтэй тэмцэх сүлжээнд бүртгүүлэх ёстой байгууллагуудад дараах шаардлагыг тавьсан:

- Эцсийн эзэмшигч гэж шууд болон шууд бусаар компанийг удирдаж, компанийн 25%-аас дээш хувьцааг эзэмшиж байгаа этгээдийг хэлнэ.
- Одоо байгаа тайлангийн компаниуд 2 жилийн дотор тайлагнах,
- Шинэ тайлан гаргах компаниуд нь үүсгэн байгуулагдах үед тайлагнах,
- Эцсийн өмчлөгчийн өөрчлөлтийг 1 жилийн дотор тайлагнах,

Энэхүү тайлагнах үүргээ зохих ёсоор гүйцэтгээгүй тохиолдолд хуульд заасан хариуцлага ногдуулахаар заасан байна.

2. AML/CFT зааварчилгааны эрсдэлд суурилсан аргачлалыг дугаарлах:

Мөнгө угаахтай тэмцэх тухай хууль нь санхүүгийн байгууллага мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх, татвараас зайлсхийх, залилан мэхлэх зэргийн эрсдэлийг үнэлэхэд гол ашиглаж байсан банкны нууцын тухай хуультай холбоотой тайланг хамруулсан эрсдэлийн суурь программыг бий болгож, мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхээс урьдчилан сэргийлэх

зорилтыг хамруулан Банкны нууцын тухай хуульд өөрчлөлт оруулсан. Практик утгаараа, мөнгө угаахтай тэмцэх тухай хууль нь банкны нууцын тухай хуульд заасан тайлан болон бүртгэлийг мэдээлэх үүрэг бүхий санхүүгийн байгууллага эрсдэлд нэвтрэхэд ашиглахыг шаарддаг, санхүүгийн байгууллага мөнгө угаах үйл ажиллагааг илрүүлэхийн тулд зохих ёсоор бүтээгдсэн эрсдэлд суурилсан программыг хэрэгжүүлэх шаардлагыг кодчилдог.

3. *AML/CFT системийг шинэчлэх:*

Мөнгө угаах гэмт хэрэгтэй тэмцэх тухай хууль технологи, инновацыг хүлээн нэвтрүүлж, бага үнэ цэнтэй үйл явцыг хялбаршуулан, хуучирсан дүрэм журам, удирдамжийг устгаж, AML/CFT системийг шинэчлэх хүрээнд дор дурдсан аргыг хэрэгжүүлнэ:

- Технологийн туршилтын дүрэм,
- Сэжигтэй үйл ажиллагааны тайлан мэдээнд өөрчлөлт оруулах,
- Эртний эд зүйлсийн худалдаа, виртуал хөрөнгийг хүлээн зөвшөөрөх,

4. *Шүүх-мөрдөн байцаахтай холбоотой эрх мэдлийг өргөжүүлсэн:*

- Иргэний шийтгэлийг чангаруулсан
- Гэмт хэрэгт ногдуулах ялыг чангаруулсан
- Гадаадын банканд нэхэмжлэл гаргах
- Шүгэл үлээгчийн урамшуулал, хамгаалалт
- FinCEN бүрэн эрхийг нэмэгдүүлсэн. Үүнд: AML/CFT хөтөлбөрийн шалгалт, хяналтыг хэрэгжүүлэх дүрэм, журам боловсруулж батлуулах, AML/CFT хөтөлбөрийн шалгалт, хяналт шалгалтыг тайлбарлахын тулд хувийн хэвшил, зохицуулагч, хууль сахиулах байгууллагуудтай тогтмол харилцах, хувийн хэвшил, төрийн банк, зээлийн холбооны удирдлагуудад санал хүсэлт өгөх, хүлээн авах, холбооны иргэн, эрүүгийн мөрдөн шалгах ажиллагаанд дэмжлэг үзүүлэхийн тулд мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхийн эсрэг мэргэжилтнүүдийг хадгалах, технологийн мэргэжилтнүүдийг хадгалах зэрэг болно.

Санхүүгийн гэмт хэрэгтэй тэмцэх сүлжээ (Financial Crimes Enforcement Network FinCEN)

1990 онд Санхүүгийн гэмт хэрэгтэй тэмцэх сүлжээг байгуулсан бөгөөд FinCEN-ийн зорилго нь санхүүгийн системийг хууль бус хэрэглээнээс хамгаалж, мөнгө угаах, терроризм болон бусад санхүүгийн гэмт хэрэгтэй тэмцэх, санхүүгийн зохицуулагчийн стратегийн хэрэглээ болон санхүүгийн мэдээллийн цуглуулалт, дүн шинжилгээ, түгээлтээр дамжуулан үндэсний аюулгүй байдлыг хангах явдал юм.

Мөнгө угаахтай тэмцэх тухай хуулийн 6103-р зүйлд заасны дагуу мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх болон бусад санхүүгийн гэмт

хэрэгтэй үр дүнтэй тэмцэхэд хууль сахиулах байгууллага, үндэсний аюулгүй байдлын байгууллага, санхүүгийн байгууллага, FinCEN нарын хооронд нийтийн болон хувийн мэдээлэл хуваалцах хамтын ажиллагааг дэмжих зорилгоор FinCEN биржийг байгуулсан.

FinCEN биржийн зорилго нь нийтийн болон хувийн хэвшлийн эрсдэлийг илүү сайн тодорхойлж, мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх болон бусад санхүүгийн гэмт хэргийг таслан зогсоох чухал мэдээллээр FinCEN болон хууль сахиулах байгууллагыг хангах боломжийг олгохын тулд нийтийн болон хувийн хэвшлийн мэдээлэл хуваалцахыг сайжруулалт, нийлүүлэлт болон хамгаалахад орших бөгөөд энэ хүрээнд дараах ажлуудыг хийхээр төлөвлөсөн байна:

1. FinCEN, хууль сахиулах байгууллага болон санхүүгийн байгууллага хоорондын харилцаа, хамтын ажиллагааг сайжруулах
2. Үндэсний аюулгүй байдал, хууль бус санхүүгийн эсрэг судалгаа, бодлогыг нэн тэргүүнд дэмжих,
3. Сэжигтэй гүйлгээний тайлангийн хэрэгжилтийг сайжруулах, хувийн хэвшлийнхэнтэй санал бодол хуваалцах,
4. Өндөр үнэ цэнтэй, үр нөлөөтэй үйл ажиллагаанд анхаарал хандуулах, боломж олгох, хүлээн зөвшөөрөх,

BSA E-Filing систем

Банкны нууцын тухай хуулиар үүрэг болгосны дагуу санхүүгийн байгууллагууд тайлан (валютын гүйлгээний тайлан, валют эсвэл мөнгөний хэрэгслийн олон улсын тээврийн тайлан, гадаадын банк, санхүүгийн дансны тайлан, сэжигтэй гүйлгээний тайлан, чөлөөлөгдсөн хүний маягт)-аа BSA E-Filing системээр дамжуулан цахим хэлбэрээр Санхүүгийн гэмт хэрэгтэй тэмцэх сүлжээнд мэдээлдэг байна. Infotech нь банк, санхүүгийн үйлчилгээ, даатгал, аж ахуйн нэгжүүдийн бизнесийг өөрчлөх IP-д суурилсан программ хангамжийн цогц шийдэл, мэдээллийн технологийн үйлчилгээ үзүүлдэг. Zi Infotech Limited нь санхүүгийн гэмт хэргийг илрүүлэх, механизмын шийдэл болох **AMLOCK™**-ыг шинээр гаргасан бөгөөд энэ нь 35 орон даяар 100 гаруй тоогоор суурилагдсан дэлхийн хэмжээний мөнгө угаахтай тэмцэх шийдэл юм. AMLOCK™ нь харилцагчийн баталгаажуулалтын байдлыг үр дүнтэй удирдах, зааварчилгааны процессыг сайжруулах, хэрэглэгчийн эрсдэлийг тасралтгүй тодорхойлох, үнэлэх цогц арга хэрэгслийг санал болгодогдоороо хамгийн сүүлийн үеийн технологи, ухаалаг график анализыг ашиглаж, хиймэл оюун ухаан болон машин сургалтын загварыг ашигладаг. Энэ нь банк, даатгал, аюулгүй байдлын байгууллагууд, ББСБ болон гар утасны түрийвч хэрэглэгчдэд сэжигтэй үйл ажиллагааг гүйлгээ ба хэрэглэгчийн түвшинд хялбархан илрүүлж, хянах боломжийг олгодог⁴.

AMLOCK™-ийн гол шинж чанарууд:

⁴ <https://www.fincen.gov> United States Department of the Treasury Financial Crimes Enforcement Network | FinCEN.gov

1. Харилцагчийн баталгаажуулалт **КҮС** - КҮС үйл явцыг сайжруулах, бэхжүүлэх хэрэгцээ шаардлагыг харгалзан AMLOCK™ нь шилжилтийг сайжруулах хэрэгслүүдийг санал болгодог.
2. Жагсаалтын үзүүлэх – харилцагч, ашиг хүртэгчид мөн харилцагч биш хүмүүсийн хэвлэгдсэн гэвэл дотоод жагсаалтаас шалгах боломжийг олгодог. Link tracer нь статистик эсвэл гүйлгээний түвшинд аж ахуйн нэгжүүдийн хоорондох далд холбоосыг тодорхойлоход тусалдаг.
3. Эрсдэл, зан төлөвийг тодорхойлох - AMLOCK™ нь мөнгө угаах эрсдэлийг данс болон хэрэглэгчийн түвшинд үнэлдэг. Эрсдэлийн ангиллын модуль нь бүх ажил гүйлгээ хийдэг байгууллагуудыг ангилах тохиргоог хийдэг. AMLOCK™ нь бэлэн байгаа статистик болон гүйлгээний өгөгдлийг ашиглан хэрэглэгчдийг танилцуулдаг. Энэ нь үйлчлүүлэгчдийн зан төлөвийг урьдчилан таамаглахад тусалдаг.
4. Сэжигтэй гүйлгээнд хяналт тавих - AMLOCK™ нь хэд хэдэн суулгагдсан дохиоллын хувилбаруудтай бөгөөд гүйлгээг хянах, сэжигтэй хэв маягийг тодорхойлох хэрэгслийг санал болгодог. AMLOCK™ нь сэжигтэй байдлын үндэс суурь болсон гүйлгээг нарийвчлан судлах боломжийг хэрэглэгчдэд олгодог бөгөөд гүйлгээний хэв маягийг олон талд байдлаар харах боломжийг олгодог.
5. Мөрдөн байцаах, тайлагнах – Суурь гүйлгээний талаарх нэмэлт мөрдөн байцаалтыг үндэслэлтэй болгохоос гадна мөрдөн шалгах ажиллагааг илүү хөнгөвчлөх бөгөөд нотлох баримтын хувиар хавсаргаж болдог.
6. Бэлэн мөнгөний гүйлгээний тайлан ба сэжигтэй гүйлгээний тайлан – Сэжигтэй гүйлгээний тайланг системд байгаа өгөгдлөөр дүүргэсэн өгөгдөлтэй хамт гаргаж болдог. Төрөл бүрийн мэдээллийн хэрэгслээр дамжуулан хянах эрх бүхий байгууллагуудад тайлан гаргахыг дэмжиж өгдөг.

Quantexa

Засгийн газруудад санхүүгийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх Quantexa бол нэгдсэн, модульчлагдсан контекстийн шийдвэрийн тагнуулын платформыг бий болгож буй стартап. Контекстийн шийдвэрийн тагнуул нь засгийн газар, санхүүгийн байгууллагуудад дүн шинжилгээ хийх, дүрслэх, өгөгдлийг нэгтгэх, сүлжээ үүсгэх шийдлээр хангадаг. Засгийн газруудын хувьд контекстийн шийдвэрийн тагнуул нь татварын луйврыг илрүүлэх, гаалийн хяналтыг сайжруулах, ашиг тусыг хянах, хүчирхэг сүлжээг дүрслэхэд ашигтай байдаг. Энэхүү шийдэл нь хууль сахиулах байгууллагуудад санхүүгийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, мөрдөн шалгах ажиллагааг сайжруулахад тусалж, харьяаллын дагуу аюулгүй байдлаар мэдээлэл хуваалцах боломжийг олгодог.

Мөнгө угаахтай тэмцэх үр дүнтэй бодлого:

- Мөнгө угаахтай тэмцэх хөтөлбөр,

- КҮС /хэрэглэгчийн хэн болохыг таних/ ба CDD/эрсдэл багатай харилцагч/
- Валютын гүйлгээг тайлагнах
- Сэжигтэй гүйлгээг мэдээлэх

II. БҮГД НАЙРАМДАХ СОЛОНГОС УЛС

Солонгос улс нь 2001 онд “Санхүүгийн үйл ажиллагааны тодорхой мэдээллийг тайлагнах, ашиглах тухай” болон “Гэмт хэрэг үйлдэж олсон орлогыг нуун дарагдуулахыг зохицуулах, ял шийтгэл оногдуулах тухай” хуулиудыг батлан, мөрдөж эхэлснээр Мөнгө угаахтай тэмцэх тогтолцоог бодитоор хэрэгжүүлж эхэлсэн бөгөөд Санхүүгийн үйл ажиллагааны тодорхой мэдээллийг тайлагнах, ашиглах тухай хуулийн дагуу мөнгө угаах үйл ажиллагаатай тэмцэх буюу мэдээлэх үүрэг бүхий санхүүгийн байгууллагаас ирүүлсэн сэжигтэй гүйлгээний тайлан зэрэг санхүүгийн мэдээллийг цуглуулж дүн шинжилгээ хийн хууль сахиулах байгууллагад шилжүүлэх чиг үүрэг бүхий санхүүгийн мэдээллийн алба /Financial Intelligence Unit, FIU/ нь 2001 оны 11 сард бие даасан байгууллагаар байгуулагдан ажиллаж байгаад 2008 оноос мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхээс урьдчилан сэргийлэх чиг үүргийг хэрэгжүүлж байна.

Тухайн улсын мөнгө угаах үйл ажиллагаатай тэмцэх тогтолцооны гол цөм нь Гэмт хэрэг үйлдэж олсон орлогыг нуун дарагдуулахыг зохицуулах, ял шийтгэл оногдуулах тухай хуулийн дагуу мөнгө угаах гэмт хэрэг, Санхүүгийн үйл ажиллагааны тодорхой мэдээллийг тайлагнах, ашиглах тухай хуулийн дагуу сэжигтэй гүйлгээг мэдээлэх, өндөр үнийн дүнтэй бэлэн мөнгөний гүйлгээг мэдээлэх, харилцагчийн *баталгаажуулалтын систем юм.*

1) Мөнгө угаах гэмт хэрэг

Солонгос улс мөнгө угаах гэмт хэргийг гэмт хэргийн төрлөөр жагсаалт гаргах замаар тодорхойлдог бөгөөд 2001 онд мөнгө угаах 38 төрлийн гэмт хэргийг тодорхойлж байснаас хойш энэ хүрээг улам өргөжүүлэн өнөөдрийн байдлаар 54 хуультай холбоотой нийт 116 төрлийн гэмт хэргийг мөнгө угаах гэмт хэрэгт тооцож байна.

Мөнгө угаах гэмт хэргийг Мансууруулах бодисын хууль бус эргэлтээс урьдчилан сэргийлэх онцгой хэргийн тухай хууль болон Гэмт хэргийн орлогыг нуун дарагдуулахыг зохицуулах, ял шийтгэл оногдуулах тухай хуулиудаар тус тус зохицуулсан бөгөөд мөнгө угаах гэмт хэрэгт,

- Мансууруулах бодисын хууль бус эргэлтээс урьдчилан сэргийлэх онцгой хэргийн тухай хуульд 7 жил хүртэл хугацаагаар хорих эсвэл 30 сая хүртэл хэмжээний воноор торгох,
- Гэмт хэргийн орлогыг нуун дарагдуулахыг зохицуулах, ял шийтгэл оногдуулах тухай хуульд 5 жил хүртэл хугацаагаар хорих эсвэл 30 сая хүртэл хэмжээний воноор торгох ял шийтгэл оногдуулахаар ялгамжтай хуульчилсан байна.

Мөн гэмт хэрэг үйлдэж олсон орлогыг хураан авахаар зохицуулсан байна.

2) Сэжигтэй гүйлгээг мэдээлэх систем

Санхүүгийн үйл ажиллагаа явуулдаг байгууллага /казино хамаарна/-ууд хууль бус хөрөнгө буюу харилцагч мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх үйл ажиллагаа явуулж байна гэж сэжиглэх үндэслэлтэй тохиолдолд санхүүгийн мэдээллийн албанд заавал сэжигтэй гүйлгээг мэдээлэх үүрэгтэй бөгөөд энэхүү мэдээлэх үүргээ биелүүлээгүй тохиолдолд, холбогдох ажилтан болон хуулийн этгээдэд хариуцлага хүлээлгэнэ. Тодруулбал, 1) Хуулийн этгээд харилцагчтай хуйвалдан сэжигтэй гүйлгээг мэдээлээгүй эсвэл худал мэдээлсэн бол 6 сарын хугацаагаар үйл ажиллагааг нь зогсоох, 2) Сэжигтэй гүйлгээний тайланг худал мэдээлсэн бол 1 жил хүртэл хугацаагаар хорих эсвэл 10 сая воны торгууль, 3) Сэжигтэй гүйлгээг мэдээлээгүй бол 30 сая хүртэл хэмжээний воны торгууль ногдуулахаар хуульчилсан байна.

3) Өндөр үнийн дүнтэй бэлэн мөнгөний гүйлгээг мэдээлэх систем

Бүгд Найрамдах Солонгос Улс өндөр үнийн дүнтэй бэлэн мөнгөний гүйлгээг мэдээлэх үүргийг 2006 оноос анх хэрэгжүүлж эхэлсэн бөгөөд мэдээлэх үндсэн хэмжээг 2006 онд 50 сая вон, 2008 онд 30 сая вон, 2010 онд 20 сая вон, 2019 оноос 10 сая вон болгон өөрчлөөд байна. Нэг удаагийн гүйлгээгээр 10 сая воноос дээш бэлэн мөнгөний орлого, зарлага хийсэн тохиолдолд харилцагчийн хэн болох, гүйлгээний огноо, гүйлгээний мөнгөн дүн зэрэг мэдээллийг компьютерын системээр дамжуулан автоматаар мэдээлэхээр зохицуулсан байна.

Өндөр үнийн дүнтэй бэлэн мөнгөний гүйлгээг мэдээлэх системийг мөнгө угаах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх аргын нэг болгон нэвтрүүлсэн нь дараах 2 шалтгаантай гэжээ:

1. Хууль бус мөнгийг хувиргахыг эрмэлздэг ихэнх мөнгө угаах үйл ажиллагаа нь өндөр үнийн дүнтэй бэлэн мөнгөний үйл ажиллагаатай холбоотой байдаг,
2. Зөвхөн санхүүгийн байгууллагын ажилтны субъектив дүгнэлтэд үндэслэсэн сэжигтэй гүйлгээний тайлангаар / сэжигтэй гүйлгээг мэдээлээгүй бол/ хууль бус хөрөнгө, мөнгийг илрүүлэхэд хязгаартай тул үүнийг нөхөх зорилготой.

Солонгос улсын хувьд бэлэн мөнгөний гүйлгээ бусад санхүүгийн гүйлгээнээс харьцангуй өндөр учраас бэлэн мөнгөний гүйлгээг мэдээлэх нь хууль бус мөнгөний урсгалыг таслан зогсоох, мөнгө угаахтай тэмцэхэд чухал үүргийг гүйцэтгэж байна гэж дүгнэсэн байна.

III. СИНГАПУР УЛС

Сингапур улс нь мөнгө угаах үйл ажиллагаатай тэмцэх хүрээнд терроризмын санхүүжилтийг таслан зогсоох тухай хууль /2002 он/, Сингапурын мөнгөний эрх мэдлийн /газар/ тухай хууль /2015 он/-ийг батлан мөрдөж байна.

Сингапур улсын мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх талаар баримтлах бодлого, стратеги төлөвлөгөө:

Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх бодлогын зорилго нь мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх үйл ажиллагааг илрүүлэх, саатуулах, урьдчилан сэргийлэх, хууль бус үйлдэл болон хууль бус мөнгөний урсгалаас санхүүгийн системийн бүрэн бүтэн байдлыг хамгаалах бөгөөд дараах 6 стратеги төлөвлөгөөтэй байна:

Стратеги 1: гадаад, дотоод бүх тохиолдолд мөнгө угаах үйл ажиллагааг мөрдөн шалгах

Стратеги 2: олон улсын үр ашигтай хамтын ажиллагааг хөхүүлэн дэмжих

Стратеги 3: хөрөнгө хураан авах

Стратеги 4: эрсдэлийг тодорхойлох

Стратеги 5: сэжигтэй гүйлгээний тайлангийн бүртгэлийн газартай хамтын ажиллагааг бэхжүүлэх

Стратеги 6: шинэ чиг хандлагад анхаарал хандуулах / мэдэхгүй хүрээг багасгах

Monetary Authority of Singapore (MAS) буюу Сингапурын мөнгөний газар:

Сингапурын мөнгөний газрыг санхүү, банкны салбарыг хянах зорилгоор 1971 онд байгуулсан бөгөөд дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

- Улсын эдийн засгийг санхүүгийн гэмт хэргээс хамгаалах,
- Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхээс урьдчилан сэргийлэх,
- Санхүүгийн байгууллага /банк, хөрөнгийн зах зээл, даатгал, төлбөрийн салбар/-уудыг зохих журмын дагуу зохион байгуулж, хяналт тавих,
- Мөнгө угаахтай тэмцэх, хэрэгжүүлэлт, финтек, сэндрокс зохицуулалт,
- Кибер аюулгүй байдлыг хангах

Санхүүгийн мөнгөний газар нь санхүүгийн байгууллагуудыг зохих журмын дагуу зохион байгуулж, хяналт тавих чиг үүргийнхээ хүрээнд санхүүгийн байгууллагуудад эрсдэлийн үнэлгээ хийн, эрсдэлийг бууруулах, харилцагчаа таньж тодорхойлох /үүнд эцсийн эзэмшигчийг оруулна/, бүртгэл хөтлөх, дансны тогтмол хяналт шалгалт хийх, аливаа сэжигтэй үйлдлийг хянах, тайлагнах, дотоод хяналтын хөтөлбөр, зааварчилгаатай байх, хяналт хариуцсан ажилтантай байх, ажилтнуудыг тасралтгүй сургах шаардлагыг Сингапурын мөнгөний газрын AML/CFT мэдэгдэл, удирдамж болон хяналтын хүлээлтийн талаарх бусад бичиг баримтуудад тодорхойлж өгөхөөс гадна санхүүгийн байгууллага аливаа шаардлагыг биелүүлээгүй эсвэл биелүүлэхээс татгалзсан тохиолдолд торгуулийн шийтгэл ногдуулахаар заасан байна.

Мөн санхүүгийн мөнгөний газар нь мөнгө угаахтай тэмцэх, хэрэгжүүлэлт, финтек, сэндбокс зэрэг зохицуулалтуудын чиг үүргийнхээ хүрээнд санхүүгийн гэмт хэрэгтэй тэмцэх зөвлөмжийн дагуу үйлчлүүлэгчид болон холбогдох этгээдүүдийн нэрсийг логик дэс дараалал ашиглан төрөл бүрийн цагны жагсаалттай тулгаж тохируулдаг нэрийн жагсаалт хийх үйл явцыг сайжруулахын тулд техник технологийн сурах, байгалийн хэлтэй уялдуулан боловсруулах арга техникийг ашиглах зорилгоор санхүүгийн гэмт хэрэгтэй тэмцэхэд хиймэл оюун ухаан ашиглах чиглэлээр мэргэшсэн “Silent Eight” фирмтэй хамтран ажилладаг байна.

Suspicious Transaction Reporting Office (STRO) буюу Сэжигтэй гүйлгээний тайлан бүртгэх газар:

Сэжигтэй гүйлгээний тайлан бүртгэх газар бол Сингапур улсын санхүүгийн мэдээллийн алба юм. Сэжигтэй гүйлгээний тайлан болон бэлэн мөнгөний гүйлгээний тайлан зэрэг бусад санхүүгийн мэдээллийг хүлээн авч, дүн шинжилгээ хийж, мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх болох бусад ноцтой гэмт хэргүүдийг илрүүлэх зорилгоор дүн шинжилгээ хийдэг. Болзошгүй зөрчлийг илрүүлсэн тохиолдолд санхүүгийн тагнуулын холбогдох шийдвэр гүйцэтгэх болон хяналт тавих байгууллагад мэдэгддэг.

DLT технологи:

Сингапур улсын Засгийн газар худалдааны санхүүжилт, төлбөр тооцоо, үнэт цаасны төлбөр тооцоог хангах, мөнгө угаахтай тэмцэх зорилгоор хэсэгчлэн, энэхүү технологийг ашиглах хувилбаруудыг судалж байгаа бөгөөд харилцагчаа таних Блокчейн шийдэл нь мөнгө угаахтай тэмцэхэд үр ашигтай, өргөтгөх боломжтой байдлаар хангах хамгийн ирээдүйтэй арга замуудын нэг гэж үзэж байна⁵.

Сингапур улсын мөнгө угаахтай тэмцэх үр дүнтэй бодлого, авч хэрэгжүүлж буй арга хэмжээ нь:

- Мөнгө угаахтай тэмцэх тухай хүчирхэг хууль тогтоомж
- Засаглал ба хяналт
- Тогтмол хяналт
- Нэр ба хориг арга хэмжээний жагсаалт
- Сэжигтэй гүйлгээг тайлагнах
- Албан хэрэг хөтлөлт, мэдээллийн менежмент
- Ажилтнуудын сургалт
- Бизнес эрхлэгчидтэй нягт хамтран ажиллах
- Идэвхтэй олон улсын хамтын ажиллагаа

⁵ Monetary Authority of Singapore. Anti-Money Laundering. <https://www.mas.gov.sg/regulation/anti-money-laundering>
Monetary Authority Singapore. Regulation. <https://www.mas.gov.sg/>

Дүгнэлт

Мөнгө угаах гэмт хэрэгтэй тэмцэх зорилго бол ахуйн хүрээнд эсхүл хохирол багатай эдийн засгийн гэмт хэргийн халдлагад өртсөн эд зүйлийг хамгаалахад чиглэдэггүй. Харин нийгэмд дэндүү их хор хөнөөлтэй, албан тушаал, авлигын бүх төрлийн гэмт хэрэг, татвар төлөхөөс зайлсхийх, хүний наймаа, хууль бус зэвсгийн худалдаа, мансууруулах төрлийн гэмт хэрэг, үндэстэн дамнасан гэмт хэргүүд, терроризм, байгалийн баялагтай холбоотой гэмт хэргээс олсон хууль бус орлого угааж буй үйлдэл рүү чиглэгддэг.

Тухайн гэмт хэрэгтэй тэмцэх нь зүгээр энгийн гэмт хэргийг илрүүлэхээс тэс ондоо, үр дагавар болох эдийн болон эдийн бус давуу талыг илрүүлэх, олон улс болон тухайн улсын эдийн засгийн цэвэр урсгалыг хар зах зээлээс хамгаалж бохир мөнгөний урсгал нөгөө талаар хууль бус санхүүжилтийг таслан зогсооход чиглэгддэг. угаах үйл ажиллагаанд ашиглагдаж буй сэжигтэй гүйлгээг илрүүлэхэд чиглэгдэж байдаг. Үүнд зөвхөн хуулийн байгууллагууд төдийгүй санхүүгийн байгууллагуудын үүрэг чухал. Иймээс санхүүгийн байгууллага бүр мөнгө угаах эрсдэлийг байнга тодорхойлж, дүн шинжилгээ хийн мөнгө угаахаас урьдчилан сэргийлэх тогтолцоог бий болгон ажиллуулах нь хамгаас чухал байна.

Иймд санхүүгийн мэдээллийн алба нь санхүүгийн байгууллагаар дамжуулан мөнгө угаах явдлын тархалтаас урьдчилан сэргийлэх, гадаад валютын шилжүүлгийг ашигласан хууль бус дотогш болон гадагш чиглэсэн урсгалыг үр дүнтэй таслан зогсоох буюу тодорхой санхүүгийн гүйлгээний мэдээллийг хянах тухайн гэмт хэрэгтэй тэмцэх маш их чухал үүрэгтэй бөгөөд дэлхийн бусад улс орнуудын хэрэгжүүлэх буй арга барил, арга замууд маш их чухал байна тухайлбал Сингапур улсын Засгийн газар мөнгө угаахтай тэмцэх зорилгоор хэсэгчлэн, DLT ашиглах хувилбаруудыг судалж байгаа бөгөөд харилцагчаа таних Блокчейн шийдэл нь мөнгө угаахтай тэмцэхэд үр ашигтай, өргөтгөх боломжтой байдлаар хангах хамгийн ирээдүйтэй арга замуудын нэг гэж үзэж байна⁶. Харин Солонгос улсын мөнгө хувьд санхүүгийн үйл ажиллагааны тодорхой мэдээллийг тайлагнах, ашиглах тухай хуулийн дагуу сэжигтэй гүйлгээг мэдээлэх, өндөр үнийн дүнтэй бэлэн мөнгөний гүйлгээг мэдээлэх, харилцагчийн баталгаажуулалтын систем гэж үзэж байна.

⁶ Monetary Authority of Singapore. Anti-Money Laundering. <https://www.mas.gov.sg/regulation/anti-money-laundering>
Monetary Authority Singapore. Regulation. <https://www.mas.gov.sg/>